

**“АРИГ БАНК” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН
ДЭЛЭГИЙН ТҮВШИНТАМИР 2022 ОНЫ 03 ДУГААР УЛИРЛЫН АЖЛЫН ТАЙЛАН**

2022 оны 10 дугаар
сарын 15-ны өдөр

Улаанбаатар хот

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 5176 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам"-ын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2022 оны 03 дугаар улирлын ажлын тайланг хүргүүлж байна.

Ариг банкны Төлөөлөн Удирдах зөвлөл нь тайлант хугацаанд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал 1 удаа, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал 3 удаа хуульд заасны дагуу танхим, цахим хэлбэрээр хуралдаж, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас холбогдох шийдвэрүүдийг гарган ажилласан байна. Үүнээс:

1. 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

- 1) Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2022 оны 07 дугаар сарын 19-ний өдөр хуралдуулахаар товлож, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022.06.30-ны өдрийн Н/95, Н/97 дугаартай “Хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, бүтцийг өөрчлөх тухай” албан бичигтэй холбогдуулан Ариг банкны хувь нийлүүлсэн хөрөнгөнд өөрчлөлт оруулсан дүрмийн өөрчлөлтийг батлахаар Т/22/37 дугаар тогтоолыг хурлаас батлан гаргав.
- 2) Ариг банкны Сүхбаатар дүүрэг дөчин мянгат тооцооны төвийн байршлыг өөрчлөх, сонирхлын зөрчилтэй хэлцэл батлах асуудлыг хэлэлцэж тус салбарыг шилжүүлэн байршлыг Улсын Их Дэлгүүрийн 1 давхарт болгон өөрчилж, тус байгууллагын эрх бүхий этгээдтэй “Түрээсийн гэрээ” хийх зөвшөөрлийг олгон хараат бус гишүүдийн 100%-ийн саналаар Т/22/38 дугаар тогтоолыг хурлаас батлан гаргав.
- 3) “Нэткапитал финанс корпораци ББСБ” ХХК-ийн хоёр тэрбум төгрөгийн бизнесийн шугамын зээлийн хүсэлтийн талаар хэлэлцэж хоёр тэрбум төгрөгийн шугамын зээлийн эрх нээлгэх гэрээ хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захиралд олгосон Т/22/40 дугаартай ТУЗ тогтоолыг гарган баталсан. Энэхүү асуудалд хараат бус гишүүн миний бие татгалзаж, бусад гишүүд дэмжсэн саналтайгаар оролцсон болно.

2. 2022 оны 09 дүгээр сарын 05-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал танхим, цахим хосолсон байдлаар хуралдсан бөгөөд миний бие гадаад улсаас цахимаар оролцож дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

- 1) “Номин тав трейд” ХХК-тай хамтарсан бизнес карт гаргахаар хамтран ажиллах, гэрээ хэлцэл хийх зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлыг хэлэлцэж “Номин тав трейд” ХХК-ийн ханган нийлүүлэгчдэдээ зориулан гаргадаг “Номин бонус карт”-ыг Ариг банкны кредит/дебит карттай нэгтгэн хамтарсан бизнес карт гаргах зорилгоор “Хамтран ажиллах гэрээ” байгуулахыг зөвшөөрч, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захиралд олгон Т/22/41 дугаар тогтоолыг хурлаас батлан гаргав.
- 2) Банкны эрх бүхий албан тушаалтан болон түүнтэй хамаарал бүхий этгээдэд зээл олгох Гүйцэтгэх захирлын эрх хэмжээг тогтоохтой холбоотой асуудлыг хэлэлцэж тэдгээрт олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 3%-иас ихгүй, тэдгээртэй холбогдох этгээдэд олгох зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтын нийлбэр дүн нь банкны өөрийн хөрөнгийн 17%-иас ихгүй байхаар

тус тус тооцож зээлийн хүсэлт шийдвэрлэж, зээл олгох, холбогдох гэрээ, хэлцлийг байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгож Т/22/42 дугаар тогтоолыг хурлаас батлан гаргав.

- 3) Банкны хэрэгцээнд шаардлагатай байгаа компьютер тоног төхөөрөмжийн худалдан авалт хийх эрх олгох, үнийг батлахтай холбоотой асуудлыг хэлэлцэж Ариг банкны өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглагдах компьютер, түүний дагалдах хэрэгслийг 155,000,000 төгрөгийн үнээр худалдан авах, худалдан авалтын нөхцөлийг тохиролцон "И Номин" ХХК-тай "Худалдах, худалдан авах гэрээ"-г байгуулахыг зөвшөөрсөн тухай Т/22/43 дугаар тогтоолыг хурлаас батлан гаргав.

3. 2022 оны 09 дүгээр сарын 14-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал танхимаар хуралдаж дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэсэн. Үүнд:

- 1) Ариг банкны төв оффисын үл хөдлөх хөрөнгийг худалдан авах саналтай танилцаад дахин нарийвчлан судлах чиглэл өгч ажиллав;
- 2) Ариг банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооноос боловсруулсан дүрэм, заавартай танилцаад хуралд оролцсон гишүүд 100%-ийн саналаар дэмжиж, Т/22/45 дугаар тогтоолын хавсралтаар батлан шийдвэрлэсэн.

Мөн 2022 оны 03 дугаар улиралд Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо нь 2 удаа хуралдаж, Дотоод аудитын газрын "Дотоод аудитын дүрэм", "Дотоод аудитын үйл ажиллагааны заавар", "Дотоод аудитын ёс зүйн дүрэм" зэрэг баримт бичгийг хэлэлцүүлэн, тус баримт бичгийн боловсруулалтад саналаа өгч ТУЗ-ийн хуралд танилцуулан батлуулж ажилласан болно.

Тайлан бичсэн:

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүн

 Д.Түвшинтамир